



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ,
ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: БНА-2020/02/ГА

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын **дарга бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат**
Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер А.Цэням
Утас: 70442424 цахим хуудас: tseenyma@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Азбаяр
Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn
Аудитор Ж.Өсөхбаяр
Утас: 99890393 цахим хуудас: usukhbayarj@audit.gov.mn



АГУУЛГА

1. УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх?.....	3
БҮЛЭГ 1. УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх?.....	5
1.1. Аймгийн сонгуулийн хорооны сонгууль зохион байгуулахад улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлохдоо шаардагдах үндсэн мэдээллийг аймгийн сонгуулийн хорооноос авсны үндсэн дээр төсөв хуваарилагдан батлагджээ.	5
1.2. Сонгуулийн хороо болон хэсгийн хороодод улсын төсвөөс сонгууль зохион байгуулах зардлыг хуваарилахдаа СЕХ-ноос ирүүлсэн төсвийн зарцуулалтын удирдамжийг мөрдөж ажилласан байна.....	5
БҮЛЭГ 2. УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх?	7
2.1. Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ыг зарим сумын сонгуулийн хороод нь мөрдөж ажиллаагүй байна.....	7
2.2. Сумдын сонгуулийн хороод зардлын тайлан үнэн зөв иж бүрэн гаргаж ирүүлээгүй байна.	8
2.3. Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлийг тайлагнаагүй байна.	9
2.4. Аймгийн Сонгуулийн хорооноос зарим сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.	10
ДҮГНЭЛТ:	12
ХАВСРАЛТУУД:	13



Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МТ	Мэдээлэл технологи



Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2019 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу гүйцэтгэв.

Аудитын зорилт

Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан УАГ-ын ГАГ, аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэв.Үүнд:

Аудитын хамарсан хүрээ

1. УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх?

Аудитын хязгаарлалт

2. УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх;

Аудитаар Баянхонгор аймгийн болон сумдын сонгуулийн хороодыг хамруулан шалгав.

Аймгийн сонгуулийн хороонд батлагдсаны дагуу хуваарилагдаж ирсэн зардлаас бусад зардал хамаарахгүй.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Гүйцэтгэлийн аудит MNS6817:2020, Гүйцэтгэлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль;
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль;
- Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.



**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер А.Цээням чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор Ж.Өсөхбаяр нар хамтран гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2020 оны 07 дугаар сарын 09-ний өдөр эхлүүлж, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж, 2020 оны 07 дугаар сарын 24-ний өдөр аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлэв.



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БҮЛЭГ 1. УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх?

Баянхонгор аймагт УИХ-ын сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс олгох зардлыг урьдчилан тооцоолохдоо шаардлагатай мэдээллийг гаргуулан авч СЕХ төсвийг тооцож удирдамж гарган хуваарилсан бөгөөд аймгийн сонгуулийн хороо нь удирдамжийн дагуу сонгуулийн хорооддоо хуваарилсан байна.

1.1. Аймгийн сонгуулийн хорооны сонгууль зохион байгуулахад улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлохдоо шаардагдах үндсэн мэдээллийг аймгийн сонгуулийн хорооноос авсны үндсэн дээр төсөв хуваарилагдан батлагджээ.

Баянхонгор аймагт 2020 оны Улсын их хурлын /цаашид УИХ гэх/ сонгуулийг зохион байгуулах улсын төсвөөс гарах зардлын хэрэгцээ шаардлагыг тодорхойлохдоо сонгогчийн тоо, сонгууль зохион байгуулахад оролцох ажилтны тоо, сум болон хэсгийн хорооны тоо тэдгээрийн байршил хоорондох зай зэрэг шаардлагатай мэдээллийг Сонгуулийн ерөнхий хороонд /цаашид СЕХ гэх/ хүргүүлсний үндсэн дээр сонгууль зохион байгуулах зардлын төсөв хуваарилагдаж ирж байна.

Хэрэгцээ шаардлагыг дээрх байдлаар тодорхойлж байгаа нь хэсгийн хорооны гишүүдийн урамшуулал, хоол, унааны зардал, мэдээ дамжуулах зардлыг тооцоолох гол үзүүлэлт болж байгаа бөгөөд харин бичиг хэрэг, сургалт сурталчилгаа, шуудан холбооны зардлыг тогтмол байхаар тооцож ирүүлсэн байна.

1.2. Сонгуулийн хороо болон хэсгийн хороодод улсын төсвөөс сонгууль зохион байгуулах зардлыг хуваарилахдаа СЕХ-ноос ирүүлсэн төсвийн зарцуулалтын удирдамжийг мөрдөж ажилласан байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн сонгуулийн хороонд 5 удаагийн удирдамжийн дагуу нийт 540968,0 мянган төгрөгийн санхүүжилтийг хуваарилсан байна. Санхүүжилтийг /Хавсралт АБ №01/хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 1. Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан зардал /мянган төгрөг/

№	Зардлын нэр	СЕХ-ны 2020.04.28-ны өдрийн 3/60	СЕХ-ны 2020.05.20-ны өдрийн 3/101 р	СЕХ-ны 2020.06.09-ны өдрийн 3/216	СЕХ-ны 2020.06.17-ны өдрийн 3/281	СЕХ-ны 2020.06.22-ны өдрийн 3/327	Нийт
1	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	250.0	0.0	0.0	0.0	0.0	250.0
2	Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-ийн гишүүн, даамлын сургалтын зардал	20,900.0	0.0	0.0	0.0	0.0	20,900.0
3	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны бичиг хэргийн зардал	4,000.0	12,600.0	0.0	0.0	0.0	16,600.0
4	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны шуудан холбооны зардал	4,000.0	15,750.0	0.0	0.0	0.0	19,750.0
5	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны унааны зардал	1,750.0	59,500.0	0.0	0.0	0.0	61,250.0
6	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	0.0	23,100.0	0.0	0.0	0.0	23,100.0



7	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардал	0.0	19,238.0	1,408.0	0.0	0.0	20,646.0
8	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	0.0	650.0	0.0	0.0	0.0	650.0
9	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	0.0	3,675.0	0.0	0.0	0.0	3,675.0
10	Сурталчилгааны зардал	0.0	5,000.0	0.0	0.0	0.0	5,000.0
11	Саналын хуудас устгах зардал	0.0	1,000.0	0.0	0.0	0.0	1,000.0
12	Томилолтын зардал	0.0	0.0	6,582.0	0.0	0.0	6,582.0
13	Болзошгүй зардал	0.0	0.0	3,000.0	0.0	0.0	3,000.0
14	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	0.0	0.0	0.0	291,630.0	16,860.0	308,490.0
15	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	0.0	0.0	0.0	43,430.0	2,520.0	45,950.0
16	Мэдээ дамжуулах унааны зардал	0.0	0.0	0.0	0.0	4,125.0	4,125.0
НИЙТ ДҮН		30,900.0	140,513.0	10,990.0	335,060.0	23,505.0	540,968.0

Дээрх зардлаас сумдын сонгуулийн болон хэсгийн хороодод нийт 470140,0 мянган төгрөгийн зардлыг хуваарилснаас 433071,0 мянган төгрөгийг сумдын сонгуулийн хорооны данс руу шилжүүлж, 37069,0 мянган төгрөгийг аймгийн сонгуулийн хорооны данснаас нэгдсэн байдлаар шилжүүлэг хийсэн байна. /Хавсралт АБ №01/

Хүснэгт № 2. Сумдын сонгуулийн хороонд хуваарилсан зардал /мянган төгрөг/

№	Зардлын төрөл	Нийт зардал	Үүнээс:		Тайлбар
			Сумдад хуваарилсан	АСХ зохион байгуулсан	
1	2.3.1 Санал авах байр бэлтгэх тохижуулах зардал	23,100.0	19,320.0	3,780.0	Нэг хэсгийн хороонд 220 мянга нийт 105 хэсгийн хороонд 23100,0 мянган төгрөг хуваарилахаас хэсгийн хорооны хаяг хийлгэсэн 16,0 мянга, төрийн далбааны 20,0 мянга нийт 3780,0 мянган төгрөгийг аймгийн СХ-ны данснаас шилжүүлсэн.
2	2.3.2 Бичиг хэргийн зардал	15,600.0	14,960.0	640.0	Нэг хэсгийн хороонд 120.0 мянга, 20 сумын сонгуулийн хороонд 150.0 мянган төгрөгөөр тооцсон. /105 * 120000₮+20*150000₮/. Нэг сонгуулийн хорооноос 32,0 мянган төгрөгийн албан маягтны үнийг аймгийн СХ-ноос шилжүүлсэн.
3	2.3.3 Шуудан холбооны зардал	18,750.0	18,750.0	-	Сумын сонгуулийн хороо болон хэсгийн хороодод тус бүр 150.0 мянган төгрөгөөр тооцсон (105 хэсэг+20хороо)*150000₮
4	2.3.4 Унааны зардал	63,625.0	63,625.0	-	Унааны зардлыг сумдын хэсгийн хороо бүрд 1000 км-ээр тооцож 1 км-ийн унааны хөлсийг 500₮-өөр, сонгуулийн хороо тус бүрийг 700₮-өөр тооцож, 1 км-ийн унааны хөлсийг 500₮-өөр, туршилтын мэдээ дамжуулах унааны зардлыг нийт хэсгийн хорооноос сумын төсвийн хэсгийн хороодыг хасаж хэсгийн хороо тус бүрд 55.0 мянган төгрөгөөр тооцсон байна. Мөн нутаг дэвсгэрийн хэмжээ том Эрдэнэцогт, Өлзийт, Баацагаан, Шинэжинст, Баян-Өндөр сумдад тус бүр 500.0 мянган төгрөг нэмж хуваарилсан байна. Харин Баянхонгор сумд 2500.0 мянган төгрөг ((105 - 11) *1000км*500₮)+(20хороо*700км*500₮)+((105-19-11хэсэг)*55000₮)+(6*500000₮) +2500000 /Баянхонгор сум/ төгрөгөөр тус тус тооцсон байна.
5	2.3.6 Урамшуулал, хоол	347,490.0	312,741.0	34,749.0	Сумын сонгуулийн хорооны 102 гишүүдэд 320.0 мянган төгрөгөөр хэсгийн хорооны гишүүд болон мэдээлэл технологийн ажилтнууд болон даамлуудад 300.0 мянган төгрөгөөр (102 *320000₮)+(759*300000₮)+(126*300000₮)+((102+759+126)*50000₮). Урамшуулал болон хоолны зардлаас суутгасан ХХОАТ-ын 34749,0 мянган төгрөгийг аймгийн СХ-нд суутган тооцож татвар шилжүүлсэн байна.



6	2.3.8. сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал;	3,675.0	3,675.0	-	Тухайн зардалд эрчим хүчний эх үүсвэргүй хэсгийн хороонд мотор ажиллуулахаар зардлыг тооцсон байна. (105 нийт хэсэг - 11 аймгийн төвийн хэсэг-19 сумын төвийн хэсэг) * 49000
	Нийт	472,240.0	433,071.0	36169.0	

Аудитын илрүүлэлт:

Нэг сумын сонгуулийн хороонд 150,0 мянган төгрөгийн бичиг хэргийн зардал хуваарилсан нь СЕХ-ны 2020 оны 3/60 дугаар албан бичгээр ирүүлсэн төсвийн зарцуулалтын удирдамжид нэг хэсгийн хорооны бичиг хэргийн зардал 160,0 мянга төгрөг байна гэж заасан заалтыг баримтлахгүйгээр хэсэг тус бүрд 10,0 мянган төгрөг дутуу хуваарилж нийт 20 хэсгийн 200,0 мянган төгрөгийг аймгийн сонгуулийн хороонд авч үлдэн зарцуулж, аймгийн сонгуулийн хороонд батлагдсан дүнг 200,0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Иймд дээрх хэтрүүлэн зарцуулсан 200,0 мянган төгрөгийг илүү зарцуулсан буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Сумдын сонгуулийн хорооны бичиг хэргийн зардлаас бусад зардлыг СЕХ-ноос ирүүлсэн удирдамжийн дагуу хуваарилсан байна.

бүлэг 2. УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх?

Сонгуулийн хороодын зардлын зарцуулалтад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс зарим сонгуулийн хороо нь төсвийг зарцуулахдаа холбогдох журмын шаардлагыг бүрэн мөрдөөгүй байна.

2.1. Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ыг зарим сумын сонгуулийн хороод нь мөрдөж ажиллаагүй байна.

Сонгуулийн Ерөнхий хорооноос Баянхонгор аймгийн сонгуулийн хороонд 540968,0 мянган төгрөг хуваарилсныг гүйцэтгэлээр бүрэн зарцуулсан байна.

Аудитаар сумдын сонгуулийн хороодын зардлын тайланг анхан шатны баримт, төрийн сангийн дансны хуулгатай тулган шалгахад дараах зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

• **Эрдэнэцогт, Жинст сумд Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.1¹, 3.2² дахь заалтуудыг зөрчиж нийт 328.2 мянган төгрөгийн зардлыг батлагдсан төсвөөс хэтрүүлэн бусад зардлаас гүйлгэн зарцуулсан байна.**

Сум	Бичиг хэргийн зардал	Шуудан холбооны зардал	Унааны зардал
Эрдэнэцогт	(178.2)	-	178.2
Жинст	(150.0)	150.0	-
НИЙТ	(328.2)	150.0	178.2

¹ Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон төв комисс, салбар комиссын дарга нь тухайн сонгуулийн хорооны зардлын дансны 1 дүгээр гарын үсгийг, томилогдсон нягтлан бодогч нь 2 дугаар гарын үсгийг зурж, энэ журмын 2.2, 2.3 дахь хэсэгт заасан хуваарилсан төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулна.

² Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ



Иймд дээрх хуваарилагдсан төсвөөс илүү зарцуулсан 328.2 мянган төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнуудаар төлүүлэх төлбөрийн актыг тогтоож аймгийн сонгуулийн хороонд хүргүүлэв.

- Эрдэнэцогт, Жаргалант, Баянцагаан сумд нийт 46.6 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7³ дахь заалтыг зөрчсөн байгаа тул холбогдох буруутай албан тушаалтнуудаар төлүүлэх төлбөрийн актыг тогтоож аймгийн сонгуулийн хороонд хүргүүлэв.

- Өлзийт сумын Сонгуулийн хороо нь хэсгийн хороодын шуудан холбооны 900.0 мянган төгрөгийн зардлаар сумын Холбооны салбараас нэгж худалдан авсан боловч хэсгийн хорооны гишүүдэд нэгж олгосон тухай баримт огт байхгүй байгаа ба аудитын явцад хэсгийн хорооны гишүүдтэй холбогдоход хэсгийн хорооны гишүүн бүрт 20.0 мянган төгрөгийн нэгж олгосон гэсэн тайлбар өгч байна.

Иймд хэсгийн хороодын шуудан холбооны зардлын анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж авахыг аймгийн Сонгуулийн хороонд зөвлөв.

- Мөн саналын хуудас устгах зардлаас 2016 оны УИХ-ын сонгуулийн саналын хуудсыг устгахад 850,0 мянган төгрөгийг устгалд оролцсон 10 хүний ажлын хөлсөнд олгож ажлын хөлснөөс ХХОАТ суутгаагүй нь ХХОАТ-ын тухай хуулийн 21.1⁴ дэх заалтыг зөрчиж 85.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутгал хийлгүй олгосон буруутай албан тушаалтаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Аудитаар байр бэлтгэх зардлаас нийт хөрөнгийн чанартай 2100,0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн бөгөөд тухайн хөрөнгийг НББ-д бүртгээгүй байгаа тул дээрх хөрөнгийг харьяа орон нутгийн байгуулагад орлогод авхуулах албан шаардлагыг Аймгийн сонгуулийн хороонд хүргүүлэв.

2.2. Сумдын сонгуулийн хороод зардлын тайлан үнэн зөв иж бүрэн гаргаж ирүүлээгүй байна.

Сумдын сонгуулийн хорооны тайланг Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3 дугаар хавсралт маягтын дагуу тайланг гаргаж ирүүлснийг аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч хүлээж авсан байна.

Сумдын ирүүлсэн зардлын тайланг анхан шатны баримтаас тулган шалгахад Эрдэнэцогт, Богд, Баянлиг, Жаргалант, Заг, Баянцагаан сумд нийт 1482.8 мянган төгрөгөөр тайланг зөрүүтэй гаргаж ирүүлсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1⁵ дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд тайланг зөрүүтэй гаргаж ирүүлсэн сумдын тайланг анхан шатны баримтын дагуу дахин гаргуулж засуулж авах албан шаардлагыг Нягтлан бодох бүртгэлийн

³ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

⁴ 21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна.

⁵ “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”



тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6⁶ дахь заалтын дагуу аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлэв.

Сонгуулийн хорооны нэр	Санал авах байр бэлтгэх тохижуулах зардал	Бичиг хэргийн зардал	Шуудан холбооны зардал	Унааны зардал	Урамшуулал, хоолны зардал	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал;	НИЙТ
Эрдэнэцогт	7.6	-	-	-	-	-	7.6
Богд	1.2	0.1	-	(187.7)	187.6	-	1.2
Баянлиг	-	3.5	-	(3.5)	-	-	-
Баянговь	-	-	-	(24.0)	-	24.0	-
Жаргалант	-	-	9.0	-	-	-	9.0
Заг	64.0	32.0	-	(18.0)	1,339.0	18.0	1,435.0
Өлзийт	-	-	-	(275.0)	-	275.0	-
Баянцагаан	-	-	30.0	-	-	-	30.0
НИЙТ	73	36	39	(508)	1,527	317	1,482.8

Аудитын илрүүлэлт:

Мөн Баацагаан сумын сонгуулийн хэсгийн хороодууд нь зардлын баримтыг бүрдүүлэхдээ тамгагүй, хүчин төггөлдөр бус 1430,7 мянган төгрөгийн анхан шатны баримт бүрдүүлэн иргэнээр падаан бичсэн боловч тухайн иргэдээс татвар суутган тооцоогүй нь ХХОАТ-ын тухай хуулийн 21.1⁷ дэх заалтыг зөрчсөн байна.

Иймд ХХОАТ-ын 143,1 мянган төгрөгийг тайлан хүлээн авахдаа хянаж хүлээж аваагүй сумын сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч нараар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Мөн Баянхонгор сумын сонгуулийн хорооны байр бэлтгэх, бичиг хэргийн зардлаас гарсан 3462,0 мянган төгрөгийн анхан шатны баримтыг аудитын явцад төлбөрийн баримтыг нөхөн бүрдүүлж зөрчлийг арилгав.

Сумдын сонгуулийн хороод нь тайлан ирүүлэхдээ тайлангийн товч танилцуулга, тодруулгыг ирүүлээгүй байхад аймгийн Сонгуулийн хорооны нягтлан бодогч хүлээж авсан байгаа нь Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 4.3.2⁸ дахь заалтыг зөрчсөн байгаа тул зөрчлийг арилгуулж аймгийн Сонгуулийн хорооны нэгдсэн тайланг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв гаргаж СЕХ-д хүргүүлэх албан шаардлагыг аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлэв.

2.3. Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлийг тайлагнаагүй байна.

Засгийн газрын 2020 оны 199 дүгээр тогтоолоор Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах явцад коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Засгийн газрын нөөц

⁶ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

⁷ 21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна.

⁸ Тайлангийн товч танилцуулга, тодруулга



сангаас нийт 2496.6 сая төгрөгийн хөрөнгө гаргаж халдваргүйжүүлэлт, ариутгал, хамгаалах хэрэгсэл худалдан авч аймгуудад хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Энэ талаар аймгийн Сонгуулийн хорооноос тодруулахад: *“сонгууль зохион байгуулахад Covid-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжилт хүлээж аваагүй бөгөөд нэг удаагийн амны хаалт, гар ариутгагч, резинэн бээлий, гялгар хүнсний бээлий, хлорын шохой зэргийг Улсын онцгой комиссоос аймгуудад хуваарилсныг хүлээн авч сумдын сонгуулийн хороонд хуваарилсан”* гэсэн тайлбарыг өгсөн бөгөөд Улсын онцгой комиссоос хэдэн төрлийн, ямар тоо хэмжээтэй хэрэгсэл хүлээн авсан тухай баримтыг аудитын хугацаанд гаргаж өгөөгүй болно. Харин нэг удаагийн амны хаалт, гар ариутгагч, резинэн бээлий, гялгар хүнсний бээлий, хлорын шохой зэргийг сумдын сонгуулийн хороодод хүлээлгэн өгсөн тухай жагсаалтыг гаргаж ирүүлсэн ба *“Сонгуулийн ирцээс хамаарч үлдээгдэл ариутгал халдваргүйтгэлийн материалыг буцааж хүлээж аваагүй, сумдын сонгуулийн хороо болон хэсгийн хороод нь харьяа Эрүүл мэндийн төвүүдэд хүлээлгэн өгсөн”* гэх тайлбар өгсөн ч ЭМТ-үүдэд хүлээлгэн өгсөн баримт ирүүлээгүй болно.

Аймгийн Сонгуулийн хорооноос аймгийн нийт сонгогчийн тоог 57511 сонгогчоор тооцож нэг удаагийн амны хаалт, бээлий, гар ариутгагч зэргийг сумдын сонгуулийн хороодод хуваарилсан ч аймгийн Сонгуулийн хорооноос ирүүлсэн судалгаагаар аймгийн хэмжээнд нийт 45290 сонгогч саналаа өгсөн байна. Иймд Засгийн газрын нөөц хөрөнгөөс зарцуулсан хөрөнгийг хэрхэн зарцуулсан талаарх тайланг иж бүрэн гаргаж ирүүлэх албан шаардлагыг аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлэв.

2.4. Аймгийн Сонгуулийн хорооноос зарим сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.

Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.4 дэх заалтын дагуу Сонгуулийн Ерөнхий Хороо нь аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын зарцуулалтад, аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавих чиг үүрэгтэй байгаа ба аймгийн сонгуулийн нягтлан бодогч нь сумдын сонгуулийн зардлын тайлан, анхан шатны баримтыг аймгаас хуваарилсан зардлын нэгтгэлтэй тулган зөрүүтэй гаргасан тайланг тухай бүр нь засуулах зэргээр хүлээж авахдаа хяналт хэрэгжүүлсэн гэх тайлбарыг өгсөн ч аудитаар зарим сумдын тайлан зөрүүтэй, анхан шатны баримт дутуу, хуваарилсан



зардлыг хооронд нь гүйлгэн зарцуулсан байгаа нь хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

Иймд аймаг, сумдын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон сумдын сонгуулийн хороодын зардлын тайланг хүлээж авахдаа хяналтыг бүрэн хэрэгжүүлж зөрчлийг давтан гаргахгүй байхыг аймгийн сонгуулийн хорооны даргад зөвлөв.

Аудитаар нийт 2902,9 мянган төгрөгийн зөрчил илэрч 802,9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2100,0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн ажиллав.



ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Баянхонгор аймагт УИХ-ын сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс олгох зардлыг урьдчилан тооцоолохдоо шаардлагатай мэдээллийг гаргуулан авч СЕХ төсвийг тооцож удирдамж гарган 540968.0 мянган төгрөг хуваарилсан бөгөөд аймгийн сонгуулийн хороо нь удирдамжийн дагуу сонгуулийн хорооддоо хуваарилсан байна.

2. Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ыг зарим сумдын сонгуулийн хороо мөрдөж ажиллаагүй, зардлын тайланг үнэн зөв иж бүрэн гаргаж ирүүлээгүй байна.

3. Засгийн газрын нөөц хөрөнгөөс үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн зарцуулалтыг тайлагнаагүй байна.

4. Аймгийн Сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ



ХАВСРАЛТУУД:

Хавсралтын нэр	Хуудасны тоо
УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах Баянхонгор аймгийн сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлийн судалгаа	1 хуудас
УИХ-ын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн Баянхонгор аймгийн сонгуулийн хорооны зардлын аудитлагдсан тайлан	1 хуудас
УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан Баянхонгор аймгийн сонгуулийн хорооны удирдах албан тушаалтны талаарх судалгаа	2 хуудас

**УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах
Баянхонгор аймгийн сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэл**

дд	Баянхонгор аймгийн Сонгуулийн хорооны нэр	Сонгуулийн насны хүний тоо		Сонгууль өгсөн хүний тоо		Хэсгийн хорооны тоо		Зардлын төсөв /сая төгрөг/		Гүйцэтгэл /сая төгрөг/		Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/	
		2016	2020	2016	2020	2016	2020	2016	2020	2016	2020	2016	2020
1	Аймгийн сонгуулийн хороо							117	68.7	117	68.7	-	-
1.1	Сумын сонгуулийн хороо							-	-	-	-	-	-
1.1.1	Баянхонгор сум	19,608	20,023	15,473	14,922	11	11	26.0	49.6	26.0	49.6	-	-
1.1.2	Баянговь сум	1,719	1,857	1,471	1,521	4	5	11.0	22.2	11.0	22.2	-	-
1.1.3	Баянлиг сум	2,289	2,463	1,885	2,090	5	5	13.2	22.9	13.2	22.9	-	-
1.1.4	Богд сум	1,910	2,000	1,612	1,597	6	6	15.3	26.1	15.3	26.1	-	-
1.1.5	Жинст сум	1,330	1,406	1,173	1,199	5	5	13.2	22.2	13.2	22.2	-	-
1.1.6	Өлзийт сум	2,375	2,530	2,027	2,144	6	6	15.3	26.6	15.3	26.6	-	-
1.1.7	Шинэжинст сум	1,447	1,548	1,217	1,303	4	4	11.0	18.8	11.0	18.8	-	-
1.1.8	Баацагаан	2,068	2,206	1,834	1,866	7	7	14.0	30.5	14.0	30.5	-	-
1.1.9	Баянбулаг	1,039	1,127	809	933	4	4	11.0	18.3	11.0	18.3	-	-
1.1.10	Баян-Өндөр	1,555	1,681	1,226	1,405	4	4	11.0	18.8	11.0	18.8	-	-
1.1.11	Баянцагаан	2,101	2,249	1,783	1,871	4	5	11.0	23.4	11.0	23.4	0.0	-
1.1.12	Бууцагаан	2,280	2,359	1,885	1,969	6	6	15.3	26.1	14.7	26.1	0.6	-
1.1.13	Бөмбөгөр	1,882	1,997	1,525	1,720	4	4	11.0	18.3	11.0	18.3	-	-
1.1.14	Хүрээмарал	1,137	1,154	935	903	5	5	13.2	22.2	13.2	22.2	-	-
1.1.15	Баян-Овоо	1,790	1,810	1,539	1,445	4	4	11.0	18.3	11.0	18.3	-	-
1.1.16	Галуут	2,905	2,665	2,189	2,254	6	6	15.3	26.1	14.1	26.1	1.2	-
1.1.17	Заг	1,359	1,347	1,128	1,144	4	4	11.0	18.3	11.0	18.3	-	-
1.1.18	Жаргалант	1,944	1,963	1,609	1,552	4	4	11.0	18.3	11.0	18.3	-	-
1.1.19	Гурванбулаг	1,302	1,415	1,109	1,179	5	4	13.2	18.3	13.2	18.3	-	-
1.1.20	Эрдэнэцогт	2,652	2,810	2,156	2,273	6	6	15.3	26.6	15.3	26.6	-	-
	Нийт дүн	54,692	56,610	44,585	45,290	104	105	385.5	541.0	266.6	541.0	1.7	-

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

БЭЛТГЭСЭН:

Б.АЗБАЯР

Ж.ӨСӨХБАЯР

ХЯНАСАН:

А.ЦЭЭНИЯМ

**УИХ-ЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ
ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН БАЯНХОНГОР АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРООНЫ ЗАРДЛЫН АУДИТЛАГДСАН ТАЙЛАН**

				төгрөгөөр
№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сонгуулийн бичиг баримт болон техник хэрэгслийг хүлээн авах, хүлээлгэх өгөх зардал;	20,646,000	20,646,000	-
2	Тогтоол, протокол, албан бичгийн хэвлэмэл хуудас, маягт хэвлүүлэх зардал	250,000	250,000	-
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал /эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх/	3,675,000	3,675,000	-
4	Дүн мэдээ дамжуулах зардал	4,125,000	4,125,000	-
5	Санал авах байр бэлтгэх тохижуулах зардал	23,100,000	23,100,000	-
6	Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-ийн гишүүн, даамлын сургалтын зардал	20,900,000	20,900,000	-
7	Урамшуулал, хоолны зардал	354,440,000	354,252,400	187,600.00
8	Бичиг хэргийн зардал	16,600,000	16,924,520	(324,520.00)
9	Шуудан холбооны зардал	19,750,000	19,600,000	150,000.00
10	Унааны зардал	61,900,000	61,913,080	(13,080.00)
11	Албан томилолтын зардал	6,582,000	6,582,000	-
12	Үнэмлэх хэвлэх зардал			-
13	Сурталчилгааны зардал	5,000,000	5,000,000	-
14	Болзошгүй зардал	3,000,000	3,000,000	-
15	Саналын хуудас устгах зардал	1,000,000	1,000,000	-
	НИЙТ ДҮН	540,968,000	540,968,000	-

БАТАЛГААЖУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Б.АЗБАЯР

Ж.ӨСӨХБАЯР

А.ЦЭЭНЯМ

ХЯНАСАН:

УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан
аймгийн сонгуулин хорооны удирдах албан тушаалтны талаарх судалгаа

Хавсралт 3
Баянхонгор

Д/А	Сонгуулийн хорооны нэр	Сонгуулийн хорооны дарга					Сонгуулийн хорооны нягтлан бодогч				
		Овог нэр	Регистрийн дугаар	Томилогдсон тушаалын огноо	Мэргэжил	Эрхэлж буй ажил албан тушаал	Овог нэр	Регистрийн дугаар	Томилогдсон тушаалын огноо	Мэргэжил	Эрхэлж буй ажил албан тушаал
1	Аймгийн сонгуулийн хороо	Цэвэлмаа ДАШЦЭРЭН	ВЙ69103111	2020.04.14 А/20	Төрийн захиргааны удирдлага	АЗДТГ-ын дарга	Эрдэнэ-Очир АМАРБАЯСГАЛАН	ВЮ88111200	2020.04.30 А/01	Нягтлан бодогч	АЗДТГ-ын нягтлан бодогч
1.1	Сумдын сонгуулийн хороо	Овог нэр	Регистрийн дугаар	Томилогдсон тушаалын огноо	Мэргэжил	Эрхэлж буй ажил албан тушаал	Овог нэр	Регистрийн дугаар	Томилогдсон тушаалын огноо	Мэргэжил	Эрхэлж буй ажил албан тушаал
1.1.1	Бх.Галуут - Сонгуулийн хороо	Түвшинжаргал АЛТАНТУЯА	ВК78010404	2020.04.22	Төрийн захиргааны удирдлага	ЗДТГ-ын дарга	Хүүхэнхүү ДҮҮРЭНХУНДАГА	ВУ70031305	2020.04.22	Цаг уурч	Цаг уурын стандартын эрхлэгч
1.1.2	Бх.Баян-Овоо - Сонгуулийн хороо	Мягав ЖАВЗАНСҮРЭН	ВЭ71020200	2020.04.22	Төрийн захиргааны удирдлага	ЗДТГ-ын дарга	Дашбазар ЭРДЭНЭБУЛГАН	ВГ86031001	2020.04.22	Нягтлан бодогч	Сумын орон нутгийн сан хариуцсан нягтлан бодогч
1.1.3	Бх.Эрдэнэцогт - Сонгуулийн хороо	Рэнцэнцадэв БОЛОРМАА	ВТ74051808	2020.04.22	Төрийн захиргааны удирдлага	ЗДТГ-ын дарга	Нацагсүрэн Дамбарал	ВЮ88081012	2020.04.22	КГХ-ийн инжнер	ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
1.1.4	Бх.Бууцагаан - Сонгуулийн хороо	Дамбахорол ЛХАГВАДОРЖ	ВЙ77121413	2020.04.22	Байгаль хамгаалагч	ЗДТГ-ын дарга	Дашбалжин ЭРДЭНЭДАЛАЙ	ВМ70011805	2020.04.22	Хуульч	ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
1.1.5	Бх.Жинст - Сонгуулийн хороо	Мишгээ ГАН-ЭРДЭНЭ	ВН78080406	2020.04.22	Нягтлан бодогч	ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга	Тогоо БОДЬТӨМӨР	ВН77021502	2020.04.22	Багш	ЕБС-ийн Сургалтын менежер
1.1.6	Бх.Богд - Сонгуулийн хороо	Дащцэрэн ДАНДАР	ЦГ69021719	2020.04.22	Нягтлан бодогч, Эдийн засагч	ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга	Жамсран БАТТУНГАЛАГ	ОЮ83091803	2020.04.22	Агрономич	ХАА-н тасгийн мэргэжилтэн
1.1.7	Бх.Баянлэг - Сонгуулийн хороо	Соном-Иш ЦЭДЭНДОРЖ	ВВ80112011	2020.04.22	Багш	ЕБС-ийн захирал	Бавуудорж ЭРДМАА	ВВ75032901	2020.04.22	Нягтлан бодогч	ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
1.1.8	Бх.Баянговь - Сонгуулийн хороо	Цэвэлхүү БУЯНТОГТОХ	ВЗ88090314	2020.04.22	Багш	ЕБС-ийн захирал	Г.Сугар-Эрдэнэ	ВБ78020305	2020.04.22	Эрхзүйч	ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
1.1.9	Бх.Гурванбулаг-Сонгуулийн хороо	Гүрээдагва ТОГТОХЖАРГАЛ	ВЛ84051511	2020.04.22	Нягтлан бодогч	Санхүүгийн албаны дарга	Самбуу АЛТАНЦЭЦЭГ	ВЙ83011503	2020.04.22	Төрийн захиргааны удирдлага	ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

1.1.10	Бх.Жаргалант - Сонгуулийн хороо	Дашцэрэн УРАНЧИМЭГ	BM85070101	2020.04.22	Нягтлан бодогч	ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга	Бэгзээ УРТНАСАН	ШДЖ86032063	2020.04.22	Малзүйч	Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн
1.1.11	Бх.Заг - Сонгуулийн хороо	Дэмбэ ГАНТУУЛ	BM70043005	2020.04.22	Төрийн захиргааны удирдлагын менежер	ЗДТГ-ын дарга	Өлзийхутаг ОЮУНЕБОЛД	BP68031211	2020.04.22	Эрхзүйч	ЭМТ-ийн нийгмийн ажилтан
1.1.12	Бх.Баацагаан - Сонгуулийн хороо	Цэрэнбат ЭНХТУЯА	ВЮ68051701	2020.04.22	Төрийн захиргааны удирдлагын менежер	ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга	Дэмчиг АНХТУЯА	ВЮ80030629	2020.04.22	Нягтлан бодогч	ЗДТГ-ын нягтлан бодогч
1.1.13	Бх.Бөмбөгөр - Сонгуулийн хороо	Баасан ЧУЛУУНДОРЖ	ВЮ70092413	2020.04.22	Төрийн захиргааны удирдлагын менежер	ЗДТГ-ын дарга	Баасан МЭНДБАЯР	ВИ75032918	2020.04.22	Төрийн захиргааны удирдлагын менежер	ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
1.1.14	Бх.Өлзийт - Сонгуулийн хороо	Батхүү БАТТУЛГА	ЦГ78042620	2020.04.22	Багш	Цэцэрлэгийн эрхлэгч	Дашхүү НАРАНТУЯА	ВП74030103	2020.04.22	Нягтлан бодогч	ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
1.1.15	Бх.Хүрээмарал - Сонгуулийн хороо	Базаррагчаа БАТСАЙХАН	BP61070316	2020.04.22	Нягтлан бодогч	ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга	Сандэгдорж НАРХУУ	BP74122201	2020.04.22	Нягтлан бодогч	ЗДТГ-ын санхүүгийн албаны дарга
1.1.16	Бх.Баянбулаг - Сонгуулийн хороо	Чунаг ГАНБОЛД	ВК80111816	2020.04.22	Хуульч	ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга	Мишиг БАТМӨНХ	ТИ70021673	2020.04.22	Нягтлан бодогч	Газрын даамал
1.1.17	Бх.Шинэжинст - Сонгуулийн хороо	Төрбат ЦЭНГЭЛМАА	ДН81020506	2020.04.22	Орчуулагч, Төрийн захиргааны удирдлага	ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга	Лхасүрэн БАТХУЯГ	ВЙ87040116	2020.04.22	Эдийн засагч	ЗДТГ-ын дарга
1.1.18	Бх.Баянцагаан - Сонгуулийн хороо	Дорж ЭНХЗАЯА	ШДЖ68122763	2020.04.22	Нягтлан бодогч	ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга	Халтар ОДОНЧИМЭГ	BE74021608	2020.04.22	Нягтлан бодогч	ХЭХАЭ мэргэжилтэн
1.1.19	Бх.Баян-Өндөр - Сонгуулийн хороо	Энхсайхны БҮЖМАА	ВД91042006	2020.04.22	Төрийн захиргааны менежер	ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга	Дэмбэрэл ЦЭЦЭГЖАРГАЛ	BC87030306	2020.04.22	Багш	ЕБС-ийн захирал
1.1.20	Бх.Баянхонгор - Сонгуулийн хороо	Гомбодорж ТӨРТӨГТОХ	ВЮ78120111	2020.04.22	Төрийн удирдлагын менежер	Аймгийн ЗДТГ-ын ХҮШДАХ-ийн дарга	Батсүх Булганаа	ВЮ83120531	2020.04.22	Төрийн удирдлагын менежер	Сумын жонжиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

БЭЛТГЭСЭН:

ХЯНАСАН:

Б.АЗБАЯР
Ж.ӨСӨХБАЯР

А.ЦЭЭНЯМ

